



29

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

“HORECA -2012” ХАНГАМЖИЙН ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 4/22, 2005 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015 хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах Улаанбаатар хот, хотын орчимд жуулчдын сонирхолыг татах үзэсгэлэн яармаг зохион байгуулах, жуулчидын үйлчилгээг сайжруулах сурталчилан таниулах зорилгоор “HORECA -2012” хангамжийн үзэсгэлэнг 2012 оны 06 сарын 12-ноос 13-ны өдрүүдэд Мишээл экспо төвд Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран зохион байгуулахыг хотын аялал жуулчлал хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д үүрэг болгосугай.

Хоёр. “Horeca-2012” хангамжийн үзэсгэлэнг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, үйл ажиллагааны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. “HORECA-2012” хангамжийн үзэсгэлэнг зохион байгуулах зардал 2.400.000 /Хоёр сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг тус газрын 2012 оны батлагдсан төсөв, төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас гаргахыг нягтлан /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Дээрх арга хэмжээг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулж, олон нийтэд хэвлэл мэдээллээр сурталчилах, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг хотын аялал жуулчлал хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/ -д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

115051000000